

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны дугаар сарын-ны өдөр

Улаанбаатар хот

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

(шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, түүний үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж

2.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулийн 7.1.-д заасан үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос тусгай зөвшөөрөл авсан компани эрхлэхтэй холбогдсон харилцааг энэхүү хуулиар зохицуулна.

3.2. Банк, даатгал, үнэт цаасны компани, тэтгэврийн сан, хадгаламж, зээлийн хоршоо, барьцаалан зээлдүүлэх газар, төслийн нэгж, Засгийн газрын тусгай зориулалттай сангаас олгох зээлийн үйл ажиллагааг холбогдох бусад хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “банк бус санхүүгийн үйл ажиллагаа” гэж Хорооноос тусгай зөвшөөрөл авсан компанийн эрхэлж байгаа энэ хуулийн 7.1.-д заасан үйлчилгээг;

4.1.2. “гадаад валютын арилжаа” гэж гадаад валютыг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр худалдах, худалдан авахыг;

4.1.3. “факторингийн үйлчилгээ” гэж зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах /шилжүүлэх/, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүрэн хариуцах үйлчилгээг;

4.1.4. “төлбөрийн баталгаа, батлан даалт гаргах” гэж Иргэний хуулийн 457, 458 дугаар зүйлд заасныг;

4.1.5.”санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах” гэж гэрээний үндсэн дээр богино болон урт хугацаат санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авахыг;

4.1.6.“үнэт цаас худалдах, худалдан авах” гэж тодорхой хязгаарын дотор хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдах үнэт цаас худалдах, худалдан авахыг;

4.1.7.“цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ” гэж бусдын мөнгөн хөрөнгийг шилжүүлэх, эсхүл интернет, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоо гүйцэтгэхийг;

4.1.8. “итгэлцлийн үйлчилгээ” гэж итгэл хүлээлгэгчийн актив /бэлэн мөнгө, зээл, бусад актив/-ыг үнэгүйдлээс хамгаалж, тэдгээртэй харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээгчээс нэр бүхий активыг гэрээнд заасан хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг;

4.1.9.”хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн гаргах” гэж иргэн, хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн нөхцөл шаардлагыг хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх, зуучлах үйл ажиллагааг;

4.1.10.”банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх компани” гэж Хорооноос энэ хуулийн 7.1.-д заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн компанийг;

4.1.11.“тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж Хорооноос энэ хуулийн 7.1.-д заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийг;

4.1.12.”холбогдох этгээд” гэж тусгай зөвшөөрөл эзэмшигч болон банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байсан, тэдэнд хувьцааны хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, тус хуулийн этгээдийн хувьцааны хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд болон Компанийн тухай хуулийн 97.1-д заасан нэгдмэл сонирхолтой этгээдийг;

4.1.13.“нэгдэл” гэж нэг хуулийн этгээд нь нөгөө хуулийн этгээдтэй холбогдох этгээд бөгөөд тэдгээрийн аль нэг нь тусгай зөвшөөрөл эзэмшигч байх тус тусдаа хуулийн этгээдийг;

4.1.14.”нэгдлийн оролцогч” гэж энэ хуулийн 4.1.13.-д заасан нөхцөлийг хангах этгээдийг;

4.1.15.“нэгдсэн хяналт, шалгалт” гэж Хорооноос нэгдлийн оролцогчдын санхүү, төлбөрийн чадвар, хөрөнгийн урсгал, санхүүгийн ажил гүйлгээний хамаарлыг тодорхойлж, үнэлэлт, дүгнэлт өгөх, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан арга хэмжээ авахыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх

5 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх компанийг үүсгэн байгуулах

5.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх компанийг Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулна.

6 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх

6.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааг Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу Монгол Улсын болон гадаадын хөрөнгө оруулалттай компани эрхэлж болно.

6.2. Төрийн өмчит хуулийн этгээд, шашны болон улс төрийн байгууллага, төрийн бус байгууллага, Иргэний хуулийн 36.2.-т заасан сан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

6.3.Энэ хуулийн 6.2.-т заасан этгээдээс төрийн бус байгууллага, сан нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцаа эзэмшигч байж болох бөгөөд төрийн өмчит хуулийн этгээд, шашны болон улс төрийн байгууллага нь энэ заалтад хамаарахгүй.

6.4. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон энэ хуулийн 7, 8, 11, 12, 15, 18 дугаар зүйлд заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, оноосон нэрийг өөрчлөх болон өөрчлөн байгуулахтай холбогдсон өргөдөл хүсэлтийг Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

6.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуулийн 11, 15 дугаар зүйлд заасан салбар, төлөөлөгчийн газар, хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдсон өргөдөл, хүсэлтийг Хорооны эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэнэ.

7 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа

7.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд дор дурдсан үйлчилгээ хамаарна:

7.1.1.гадаад валютын арилжаа;

7.1.2.зээл;

7.1.3.факторинг;

7.1.4.санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах;

7.1.5.үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлал;

7.1.6.хөрөнгө оруулалтын болон санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;

7.1.7.төлбөрийн баталгаа, батлан даалт гаргах;

7.1.8.төлбөр тооцооны хэрэгсэл гаргах;

7.1.9.цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга;

7.1.10.итгэлцэл;

7.1.11.хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн гаргах;

7.1.12.хууль тогтоомжоор хориглоогүй бөгөөд Хорооноос зөвшөөрсөн бусад санхүүгийн ажил, үйлчилгээ.

7.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үйлчилгээ эрхэлж болно. Үүнд:

7.2.1.санхүүгийн түрээс;

7.2.2.даатгалын төлөөлөгч;

7.2.3.даатгалын зуучлагч;

7.2.4.үнэт цаас худалдах, худалдан авах.

7.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг анх олгосноор энэ хуулийн 7.1.1.-7.1.6., 7.2.1.-7.2.3.-д заасан үйлчилгээг эрхлэх үндэслэл бүрдэх бөгөөд 7.1.7.-7.1.12., 7.2.4.-д заасан үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг Хороо нэмэлт зөвшөөрлийн хүрээнд хянан, шийдвэрлэнэ.

7.4. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага болон энэ хуулийн 7.1, 7.2.-д заасан үйлчилгээтэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Хороо батална.

8 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр

8.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр нь түүний оноосон нэр болон дараах дэлгэрэнгүй тэмдэглэгээнээс бүрдэнэ:

8.1.1.энэ хуулийн 7.1.1.-д заасан үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч “Валют арилжааны байгууллага”;

8.1.2.энэ хуулийн 7.1.1.-7.1.6., 7.2.1.-7.2.3.-д заасан үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч “Зээлийн байгууллага”;

8.1.3.энэ хуулийн 7.1.1.-7.1.12., 7.2.1.-7.2.4.-д заасан үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч “Санхүүгийн байгууллага”.

8.2. Энэ хуулийн 7.1.-д заасан үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс өөр этгээд өөрийн оноосон нэртэй хамт энэ хуулийн 8.1.1.-8.1.3.-д заасан тэмдэглэгээ хэрэглэхийг хориглоно.

8.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн оноосон нэрийг Хорооны зөвшөөрөлтэйгээр өөрчилнө.

8.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 8.1.1.-8.1.3.-д заасан тэмдэглэгээг Хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу хэрэглэнэ.

8.5. Энэ хуулийн 8.1.1.-8.1.3.-д заасан тэмдэглэгээ хэрэглэх компанид тавигдах нөхцөл шаардлага, шалгуур үзүүлэлтийг Хороо тогтооно.

9 дүгээр зүйл. Бүрдүүлэх баримт бичиг

9.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх компани нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.-д заасан болон дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ:

9.1.1.банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

9.1.2.банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

9.1.3.дүрэм, холбогдох үйл ажиллагааны журам;

9.1.4.хуулийн этгээдийн нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

9.1.5.Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан болохыг нотлох баримт бичиг;

9.1.6.хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлэх хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох гарал үүслийн талаарх мэдээлэл, тодорхойлолт, бусад баримт бичиг;

9.1.7.бизнес төлөвлөгөө;

9.1.8.эхлэлтийн баланс;

9.1.9.эрх бүхий албан тушаалтан, боловсон хүчин, техник, тоног төхөөрөмж, ажлын байрны талаарх мэдээлэл, тодорхойлолт;

9.2. Энэ хуулийн 9.1.-д заасан баримт бичгийг бүрдэл дутуу, хангалтгүй гэж үзвэл Хороо нэмэлт баримт бичиг шаардах эрхтэй бөгөөд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх компанийн хувьцаа эзэмшигч, удирдлагатай холбоотой болон бусад шаардлагатай асуудлаар холбогдох байгууллагаас тодорхойлолт, лавлагаа гаргуулан авч болно.

9.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх компани нь энэ хуулийн 9.1.-д зааснаас гадна энэ хуулийн 7.4.-т заасан журам, нөхцөл шаардлагыг хангасан баримт бичгийг ирүүлнэ.

10 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрэм

10.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2.-т заасан болон дараах зүйлийг тусгана:

10.1.1. хувьцаа эзэмшигчдийн бүртгэл, тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, эзэмшиж байгаа хувьцааны тоо;

10.1.2. удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц;

10.1.3. эрхлэх үйлчилгээ

10.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш ажлын 10 хоногийн дотор Хороонд хүргүүлнэ.

11 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

11.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхийг хүсч ирүүлсэн баримт бичгийг Хороо хүлээн авч ажлын 30 хоногийн дотор хянаад, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журамд заасан болон дор дурдсан нөхцөл шаардлагыг хангасан тохиолдолд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно:

11.1.1. хувь нийлүүлсэн хөрөнгө нь Хорооноос тогтоосон доод хэмжээг хангасан;

11.1.2. хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлэх хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн;

11.1.3. бизнес төлөвлөгөөнд банк бус санхүүгийн үйл ажиллагааны стратеги, нөлөөлөх хүчин зүйлийг тусгасан;

11.1.4. удирдлага нь энэ хуулийн 14.6, 14.7.-д заасан шалгуурыг хангасан;

11.1.5. техник, тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан;

11.1.6. энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийн шаардлагыг хангасан.

11.2. Ирүүлсэн баримт бичгийг магадлан шинжлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд Хороо энэ хуулийн 11.1.-д заасан хугацааг ажлын 15 хоногоор сунгаж болно.

11.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгох ба уг зөвшөөрөл нь олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

11.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь салбар, төлөөлөгчийн газрыг Хорооны зөвшөөрөлтэйгээр нээнэ.

11.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн болон харъяа салбар, төлөөлөгчийн газрын оршин байгаа хаягийн өөрчлөлтийн талаар Хороонд мэдэгдэнэ.

11.6. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд эрхлэх үйлчилгээг тодорхой заана.

11.7. Хороо дараах үндэслэлээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

11.7.1. энэ хуулийн 11.1.-д заасан нөхцөл шаардлагыг хангаагүй;

11.7.2.ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь баримтаар тогтоогдсон;

11.7.3.хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах хөрөнгийг зээлийн эх үүсвэрээр бүрдүүлсэн нь нотлогдсон;

11.7.4.ирүүлсэн баримт бичиг нь холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрт нийцээгүй;

11.7.5.зөвшөөрөл хүсэгчийн буруугаас ирүүлбэл зохих баримт бичгийн бүрдэл нь анх хүсэлт тавьсан өдрөөс хойш 6 сарын хугацаа өнгөрсөн.

11.8. Энэ хуулийн 11.7.2.-д заасан үндэслэлээр Хороо банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохоос татгалзсанаас хойш 1 жилийн дотор тухайн компаниас дахин зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хүлээн авахгүй.

12 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

12.1. Хороо банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

12.1.1.энэ хуулийн 15.2.-т заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаагүй;

12.1.2.энэ хуулийн 13.1., 15.5.-д заасныг зөрчсөн;

12.1.3.энэ хуулийн 14.1.-14.3.-д заасан шаардлагыг 3 улирал дараалан хангаагүй.

12.2. Энэ хуулийн 12.1.-д заасан түдгэлзүүлсэн үндэслэл арилсан бол тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн сэргээнэ.

12.3. Хороо банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

12.3.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан;

12.3.2.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаагаа сэргээлгэх тухай хүсэлт бүхий албан бичиг ирүүлээгүй,

12.3.3.түдгэлзүүлсэн хугацаанд энэ хуулийн 12.1.-д заасан түдгэлзүүлсэн үндэслэл бүхий зөрчлийг арилгах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй;

12.3.4. энэ хуулийн 12.1.-д заасан үндэслэлээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шийдвэр гаргасан өдрөөс хойш тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бусдаас эх үүсвэр нэмж татан төвлөрүүлсэн;

12.3.5.тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсоныг зарласан, эсхүл татан буугдсан тухай эрх бүхий байгууллага, хувьцаа эзэмшигчдийн хурлаас зарласан;

12.3.6.банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

12.3.7.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 1 жилээс дээш хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй.

12.4. Хороо тусгай зөвшөөрөл эзэмшигчийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай мэдээллийг олон нийтэд мэдээлнэ.

12.5. Хороо тусгай зөвшөөрөл эзэмшигчийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш 1 жилийн дотор тухайн компаниас дахин зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хүлээн авахгүй.

12.6. Хуульд заасан үндэслэлээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг Хороо хариуцахгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид хориглох зүйл, тавигдах шаардлага

13 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид хориглох зүйл

13.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

13.1.1.энэ хуулийн 7.1., 7.2.-д зааснаас бусад үйл ажиллагаа, үйлчилгээ эрхлэх;

13.1.2.өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх;

13.1.3.иргэн, хуулийн этгээдээс аливаа хэлбэрээр хадгаламж авах, хадгаламжийн данс нээх;

13.1.4.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тайлан тэнцэлд тусгаагүй эх үүсвэрийг өөрийн үйл ажиллагаанд ашиглах.

13.2. Зээлийн барьцаалсан эд хөрөнгийг зээл төлүүлэх зорилгоор эзэмших, худалдаж борлуулах үйл ажиллагаа энэ хуулийн 13.1.1.-д хамаарахгүй.

13.3. Өөрийн компани, харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, дотоод хяналтын албаны дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтанд хориглоно:

13.3.1.тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

13.3.2.Хороо, түүний хянан шалгагч хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан;

13.3.3.шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл авилгатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шаардлагаар тэдгээрийн удирдлагын хүсэлтийг прокурор зөвшөөрсөн;

13.3.4.Монгол Улсын хуулийг зөрчсөн нь нотлогдсон бол олон улсын хуулийн байгууллага, Монгол Улстай эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан гадаад улсын Засгийн газар хүсэлт гаргасан.

13.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгосон зээлийн талаарх эрх бүхий байгууллага хоорондын мэдээлэл, зээлийн мэдээллийн санд гаргаж өгөх мэдээлэл, энэ хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан тайлан, мэдээлэл болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчтай солилцох мэдээлэл энэ хуулийн 13.3.-д хамаарахгүй.

14 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлага

14.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 7.3.-т заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана.

14.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгаа, батлан даалтын

нийлбэр дүн нь тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрч болохгүй.

14.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гаргах төлбөрийн баталгаа, батлан даалтын нийт дүн нь тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрийн хөрөнгийн 70 хувиас илүүгүй байна.

14.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, бусад ажилтан болон энэ хуулийн 4.1.12.-д заасан этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын дээд хэмжээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрийн хөрөнгийн 10 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 25 хувиас тус тус хэтэрч болохгүй бөгөөд ийнхүү олгоходоо дараах шаардлагыг баримтална:

14.4.1. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан хөрөнгийг барьцаалан зээл олгохгүй байх;

14.4.2. олгосон зээлийн төлөгдөх хугацаа нь зургаагаас дээш сараар хэтэрсэн бол тухайн этгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчийг удирдах үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцохыг хориглох.

14.5. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Хорооноос тогтоосон журмын дагуу хангаж биелүүлнэ.

14.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага дараах шалгуурыг хангасан байна:

14.6.1. зээлийн гэрээ буюу өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд төлбөрийн баталгаа, батлан даалтаар хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

14.6.2. ял шийтгэлгүй.

14.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гүйцэтгэх удирдлага нь банк, санхүү, эдийн засгийн мэргэжилтэй, тухайн салбарт ажилласан туршлагатай байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрийн хөрөнгө, санхүүгийн тайлан

15 дугаар зүйл. Өөрийн хөрөнгө

15.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хөрөнгөтэй байна. Өөрийн хөрөнгийг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хорооны хамтран баталсан нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу тодорхойлно.

15.2. Хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдээс оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний хэмжээг улсын эдийн засгийн байдал, мөнгөний ханшийн өөрчлөлт, салбарын хөгжлийн чиг хандлага, эрхлэх үйлчилгээний онцлог, газар зүйн байршлыг харгалзан Хороо тогтооно.

15.3. Өөрийн хөрөнгийн хэмжээг ашиг, алдагдлаараа буюу зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санг илүү, дутуу байгуулсан хэсгээрээ нэмэгдүүлж, эсхүл хорогдуулж тодорхойлно.

15.4. Хувьцаа эзэмшигч хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан хөрөнгийн хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээж, алдагдлыг нөхнө.

15.5. Хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах бүрт Хороонд мэдэгдэж зөвшөөрөл авна.

15.6. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, худалдан авах, шилжүүлэхэд мөрдөх журмыг Хороо батална.

16 дугаар зүйл. Санхүүгийн тайлан

16.1. Санхүүгийн тайлан нь баланс, үйл ажиллагааны үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тэдгээрт хавсаргасан тайлбар, тодруулга, хавсралт тооцооноос бүрдэнэ.

16.2. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хорооны хамтран баталсан нягтлан бодох бүртгэлийн журамд нийцсэн байна.

16.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь санхүүгийн үйл ажиллагааны мэдээллийн санг давагдашгүй хүчин зүйл, бусад аюулаас сэргийлэх зорилгоор архивын биет болон цахим хэлбэрээр хадгална.

16.4. Хороо нь санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв эсэхэд хяналт тавьж, зохих журмыг баримтлаагүй, буруу, ташаа, алдаатай бол залруулахыг шаардаж, биелэлтэд хяналт тавьж ажиллана.

17 дугаар зүйл. Санхүүгийн тайлан, бусад шаардлагатай мэдээллийг тайлагнах

17.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь санхүүгийн тайлан болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

17.2. Шаардлагатай гэж үзвэл Хороо сар бүрийн санхүүгийн тайлан, мэдээг шаардаж болно.

17.3. Хороо санхүүгийн тайлантай холбогдсон нэмэлт тодруулгыг тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний нэгдлийн оролцогч толгой компани, тэдгээрийн хараат болон охин компаниас шаардах эрхтэй.

17.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, нэгдлийн оролцогч, түүнтэй холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь Хорооны хянан шалгагчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоогоор хангана.

18 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах

18.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг Хорооны зөвшөөрлийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулж болно.

18.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг өөрчлөн байгуулах тухай зөвшөөрөл авахад дор дурдсан баримт бичгийг Хороонд гаргаж өгнө:

18.2.1. өөрчлөн байгуулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;

18.2.2. өөрчлөн байгуулах шаардлага, хэлбэр, нөхцөл, хугацааг заасан баримт бичиг, банк бус санхүүгийн үйл ажиллагааг дуусгавар болгохтой холбогдуулан авах арга хэмжээ, тэдгээрийн хугацаа, үе шат, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, аудитын байгууллага /аудитор/-аар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон шаардлагатай бусад мэдээлэл.

18.3. Хороо баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигчийг өөрчлөн байгуулах тухай холбогдох асуудлыг шийдвэрлэж нийтэд мэдээлнэ.

18.4. Өөрчлөн байгуулах зөвшөөрөл олгосны дараа тусгай зөвшөөрөл эзэмшигчийг өөрчлөн байгуулах ажиллагаа эхэлнэ.

18.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Хорооноос өөрчлөн байгуулах талаар гарсан шийдвэрийг гаргаснаас хойш 10 хоногийн дотор харилцагчиддаа мэдэгдэнэ.

18.6. Өөрчлөн байгуулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хууль тогтоомж зөрчсөн, харилцагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол Хороо зөвшөөрөл өгөхөөс татгалзана.

ТАВДУГААР БҮЛЭГ

Холбоо

19 дүгээр зүйл. Холбоо

19.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь хууль ёсны эрх ашгаа хамгаалуулах, хамтран ажиллах зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдэн холбоо /цаашид “Холбоо” гэх/ байгуулж болно.

19.2. Хорооноос тогтоосон шалгуурыг хангасан холбоо нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч компаниудын үндэсний холбооны эрх, үүргийг хэрэгжүүлж гишүүдийн эрх ашгийг хамгаалах, тэдгээрийг төрийн байгууллага болон гадаад харилцаанд төлөөлөх эрхийг эдэлнэ. Бусад холбоо нь “үндэсний” гэх тодотголыг оноосон нэрд хэрэглэхийг хориглоно.

19.3. Холбооны дүрэм, удирдлагын зохион байгуулалт, эрх үүрэг нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

19.4. Холбоо нь оноосон нэр, тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас, харилцах данс бүхий Монгол Улсад бүртгэлтэй этгээд байна.

20 дугаар зүйл. Холбооны эрх, үүрэг

20.1. Холбоо нь дараах эрх эдэлнэ:

20.1.1. гишүүдийнхээ хууль ёсны эрх, нийтлэг ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах;

20.1.2. холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр төрийн байгууллагад санал оруулах, тэдгээрийн боловсруулсан хууль тогтоомжид санал өгөх;

20.1.3. гишүүдийнхээ үйл ажиллагаанд баримтлах нийтлэг журам, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг батлах, хэрэгжилтийг хангуулах;

20.1.4. хуульд заасан нууцад хамаарахаас бусад мэдээллийг гишүүн байгууллагаас гаргуулах;

20.1.5. хууль тогтоомжийн хүрээнд гишүүдийн үйл ажиллагааг дэмжих, олон нийтэд сурталчлах;

20.1.6. гишүүдийн татварын хэмжээг тогтоох;

20.1.7. хууль тогтоомжид заасан бусад.

20.2. Холбоо нь дараах үүрэг хүлээнэ:

20.2.1. салбарын нэгдсэн сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

20.2.2. гишүүдийн мэргэжлийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч, хэрэгжүүлэх;

20.2.3. гишүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;

20.2.4.салбарын үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт гаргах;

20.2.5.гишүүдийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хороо болон эрх бүхий бусад байгууллагаас ирүүлсэн аливаа мэдээллийг гишүүн бүрт шуурхай хүргэх;

20.2.6.хууль тогтоомжид заасан бусад.

21 дүгээр зүйл. Холбооны хөрөнгийн эх үүсвэр

21.1. Холбооны хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэж болно:

21.1.1.гишүүний татвар, хандив, төлбөр;

21.1.2.гадаад, дотоодын этгээдээс оруулсан хандив, зээл, тусламж;

21.1.3.дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны орлого;

21.1.4.зээлийн, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө;

21.1.5.хууль тогтоомжоор хориглоогүй, дүрэмд заасан бусад эх үүсвэр.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт, хүлээлгэх албадлагын арга хэмжээ

22 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт

22.1. Хороо энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчид хяналт тавьж, шалгалт хийнэ.

22.2. Хороо нь хяналт, шалгалт болон шаардлагатай бусад тохиолдолд тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбоотойгоор бусад этгээдээс тодруулга, мэдээлэл авах эрхтэй.

23 дугаар зүйл. Нэгдсэн хяналт, шалгалт хийх

23.1. Нэгдсэн хяналт, шалгалтыг энэ хуулийн 4.1.15.-д заасан хүрээнд хийнэ.

23.2. Хороо нь нэгдлийн оролцогчдын үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагатай хамтран нэгдсэн хяналт, шалгалт хийж болно.

23.3. Нэгдлийн оролцогч нь өөр улсад бүртгэгдсэн буюу байршдаг бол Хороо тухайн орны эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллаж нэгдсэн хяналт, шалгалтыг хэрэгжүүлж болно.

23.4. Нэгдсэн хяналт, шалгалтын хүрээнд нэгдлийн оролцогч нь нэгдсэн хяналт, шалгалтад зориулан өөрийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд, түүний удирдлага бүтэц, зохион байгуулалт, санхүүгийн тайлан мэдээ болон шаардлагатай бусад мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.

23.5. Нэгдлийн аливаа оролцогчийн санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллага /аудитор/-ын дүгнэлтийг Хороо шаардах эрхтэй.

24 дүгээр зүйл. Нэгдсэн хяналт шалгалтад хамрагдахгүй байх нөхцөл

24.1. Хороо нэгдсэн хяналт шалгалтын үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл эзэмшигчмэй нэгдлийн оролцогчийг дараах тохиолдолд оролцуулахгүй байж болно:

24.1.1.үйл ажиллагааны төрөл, хэмжээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санхүү, төлбөрийн чадварын байдалд нөлөө үзүүлдэггүй;

24.1.2. тухайн хуулийн этгээдийг нэгдсэн хяналт шалгалтад хамруулахгүй байх нь нэгдсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа зохих ёсоор хэрэгжүүлэхэд саад болохооргүй.

24.2. Нэгдсэн хяналт шалгалтад хамруулахгүй бол энэ тухай Хороо тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч болон түүний толгой компани, тухайн оролцогчид мэдэгдэнэ.

25 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүлээлгэх албадлагын арга хэмжээ

25.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлага, Хорооны бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргасан шийдвэрийг зөрчсөн нь хяналт, шалгалтаар тогтоогдсон нөхцөлд Хороо дор дурдсан албадлагын арга хэмжээ авна:

25.1.1. албан бичгээр сануулах, зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

25.1.2. энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан захиргааны шийтгэл ногдуулах;

25.1.3. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох, хязгаарлах, түдгэлзүүлэх;

25.1.4. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох.

25.2. Хороо тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан зөрчилд энэ хуулийн 25.1.1, 25.1.2.-т заасан арга хэмжээг авсан боловч Хорооны шийдвэрт заасан хугацаанд уг зөрчлийг арилгаагүй бол энэ хуулийн 25.1.3., 25.1.4.-д заасан арга хэмжээ авна.

25.3. Албадлагын арга хэмжээ авах тухай Хорооны шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл тухайн этгээд шүүхэд гомдол гаргаж болно.

25.4. Албадлагын арга хэмжээ ногдуулсан нь бусад хууль тогтоомжийн дагуу хүлээлгэх хариуцлагаас тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний эрх бүхий албан тушаалтныг чөлөөлөх үндэслэл болохгүй.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

Хариуцлага

26 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

26.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Хорооны хянан шалгагч дараах захиргааны шийтгэл ногдуулна:

26.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч нь салбар, төлөөлөгчийн газрыг зөвшөөрөлгүй нээсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

26.1.2. хяналт, шалгалтад саад учруулсан иргэнийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, ажилтан, албан тушаалтныг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

26.1.3. төлбөр тооцооны баримтыг нуун дарагдуулсан буюу гүйлгээг саатуулсан ажилтан, албан тушаалтныг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигчийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

26.1.4.тайлан, тэнцэл, мэдээ баримтыг Хороонд зохих журмын дагуу гаргаж өгөөгүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, эсхүл буруутай ажилтан, албан тушаалтныг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

26.1.5.энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

26.1.6.санхүүгийн тайланд хуурамч, худал мэдээлэл агуулагдсан бол тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

26.1.7.энэ хуулийн 13.1.2.-т заасныг зөрчин хуурамч, худал, ташаа мэдээлэл бүхий зар сурталчилгааг тараасан бол тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

26.1.8.энэ хуулиар хориглосон болон Хорооноос зөвшөөрснөөс өөр үйл ажиллагаа эрхэлсэн бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн тухайн үйлчилгээнээс олсон орлогыг хурааж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, эсхүл буруутай ажилтан, албан тушаалтныг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

26.1.9.нэгдсэн хяналт, шалгалтын дүгнэлтээр буруутай нь тогтоогдсон нэгдлийн аливаа оролцогч этгээдийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

26.1.10.энэ хуулийн 22.2.-т заасан этгээд нь тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбоотойгоор Хорооноос шаардсан тодруулга, мэдээллийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гаргаж өгөхөөс зайлсхийсэн тохиолдолд тухайн этгээдийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

26.1.11.энэ хуулийн 26.1.1.-26.1.10.-т заагдсанаас бусад байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар Хорооноос гаргасан шийдвэрийг биелүүлээгүй нь мөн энэ хуулийн 12.1., 12.4.-т заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл болохгүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, эсхүл буруутай ажилтан, албан тушаалтныг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, торгох;

26.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг Иргэний хуулийн дагуу нөхөн төлүүлнэ.

26.3. Энэ хуулийн 26.1.-д заасан торгуулийг үндэслэлгүй ногдуулсан гэж үзвэл шүүхэд гомдол гаргаж болно.

27 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

27.1. Энэ хуулийг 201... оны дугаар сарын-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА /З.ЭНХБОЛД